



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019/05



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-13
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	14
Нэг. Эрүүл мэнд.....	15-16
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	17-19
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	20-23
Дөрөв. Гэмт хэрэг.....	24-25
Тав. Мөнгө, зээл.....	26
Зургаа. Төсөв, санхүү	27-28
Долоо. Үнэ	29-32
Найм. Хөдөө аж ахуй.....	33-35
Ес. Аж үйлдвэр	36-40
Арав. Байгаль орчин	41

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2019 оны 05 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 05 сард 520 эх амаржиж, 522 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 43(7.6)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 43(7.6)-аар тус тус буурсан байна. 2019 оны 05 сарын байдлаар 167 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 7(4.4)-оор өсчээ.

Хүн амын цэвэр өсөлт 355 болж 2018 оны мөн үеийнхээс 50(12.3)-аар буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 8.2, нас баралт 2.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.2 пунктээр, нас баралт 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2016-2019 оны 05 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 3 байна.



1.2 Эрүүл мэнд


2019 оны 05 сарын байдлаар 171.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар, 7.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурч, 4.6 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

2019 оны 05 сард 775 эх жирэмсний хяналтанд орсны 89.0 хувь буюу 690 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.5 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 8.8 мянган удаа гарсны 1.3 мянга буюу 14.8 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 1.1 хувиар өсч, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 1165 хүн бэртэж, 33 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 134(10.3%)-өөр буурч, нас барсан хүний тоо 1(3.1%)-ээр хувиар өсчээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 05 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 25.7 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 24.6 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл 19.8 хувь, бусад төрлийн өвчин 13.2 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 9.6, хоол шингээх эрхтний өвчин 7.2 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 407 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 101-ээр буюу 33.0 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд вирус гепатит 50.0 хувь, тэмбүү 51.2, трихонминиаз 88.9 хувь, бусад төрлийн өвчин 48.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.



1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 05 сарын эцэст 885 болсны 869 (98.2%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 16 (1.8%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 25 (2.9%) хүнээр өсч, өмнөх сараас 212 (31.5%) хүнээр өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 460 (52.0%) нь Сайншанд суманд, 179 (20.2%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 596 (67.3%) нь бүрэн дунд, 114 (12.9%) нь дээд, 67 (7.6%) нь бүрэн бус дунд, 37 (4.2%) нь техник болон мэргэжлийн, 36 (4.1%) нь тусгай дунд, 20 (2.3%) нь боловсролгүй 13 (1.5%) нь бага, 2 (0.2%) нь магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2019 оны 05 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны 05 сарын эцэст 3 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 220 иргэн ажилд зуучлагдан орж, 192 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 231 ажлын байрны 93 (40.3%) нь энгийн ажил, 37 (16.0%) нь техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 32 (13.9%) нь мэргэжилтэн, 18 (7.8%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 15 (6.5%) нь хөдөө аж ахуй, ой загас агнуурын ажилтан, 11 (4.8%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 9 (3.9%) нь контор үйлчилгээний ажилтан, 16 (6.9%) бусад салбарын ажлын байрны захиалга байна.

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар




1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 05 сарын байдлаар 17085.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4076.3(31.3%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 5 сард өмнөх



оны мөн үеэс 4076.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2607.4(31.9%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 623.1(28.5%) ҮОМШӨ-ний даатгал 431.2(32.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 296.5(32.0%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2019 оны 05 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 20999.4 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 3046.4(17.0%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 15246.5(72.6%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2879.5 (13.7%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1210.9(5.8%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1248.2(5.9%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 414.3(2.0%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 05 сард нийгмийн халамжийн сангаас 20612 иргэнд 3459.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 672 (3.4%)-өөр өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж 119.8 (3.6%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2019 оны 05 сард 1436 хүн хамрагдсан нь өмнөх оноос 130 (10.0%)-оор өсч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 110.5 (11.8%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 1035 иргэнд 322.6 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 825 иргэнд 264.4 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 6873 иргэнийг хамруулж, 262.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 10443 иргэн хамрагдаж, 1564.2 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 оны 05 сарын байдлаар 242 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 48 хүн гэмтэж, 14 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 9 (3.6%)-өөр, гэмтсэн хүний тоо 44(47.8%) –өөр буурч, нас барсан хүний тоо 4 (40.0%)-өө нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12 (92.3%)-оор, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 (66.7%)-өөр, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2 (40.0%)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 (30.4%)-оор, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 4 (23.5%)-ээр, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 23 (21.1%)-аар тус тус буурч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 35.5 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 31.8 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 6.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.8 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 5.4 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 5.0 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 4.1 хувийг хүний амины гэмт хэрэг, 5.8 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 57 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 (2.2 дахин)-оор нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Даланжаргалан, Иххэт, Эрдэнэ, Сайншанд сумдад нэмэгдэж, Сайхандулаан суманд өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2424.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2044.0(5 дахин) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 453.1 (18.7%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 79 (32.6%) нь гэр орон сууцандаа, 57 (23.6%) нь согтуугаар, 24(9.9%) нь гудамж олон нийтийн газарт, 17 (7.0%) бүлэглэн, 30(12.4%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 67 (27.7%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 663 хүн саатуулагдаж, 102 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2019 оны 05 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 512.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 84.9 (14.2%) сая төгрөгөөр, цэвэр зарлага 496.4 тэрбум төгрөг болж 120.8 (19.6%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2018-2019 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2018-2019 он, сая.төг



Иргэдийн мөнгөн хадгаламж 115.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1721.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1659.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 1.7 (2.5%) мянган хүнээр буурч, хадгаламжийн үлдэгдэл 25.7 (28.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 5 дугаар сарын эцэст 4336.7 сая төгрөг болж, өмнөх сараас 199.8 (5.0%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2095.8 (93.5%) сая төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.5 хувийг эзэлж, өмнөх сараас 0.4 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр тус тус өсчээ.

Чанаргүй зээл 5 дугаар сарын эцэст 6831.4 сая төгрөг болж өмнөх сараас 304.7 (4.7%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 1820.7 (21.0%) сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019.5 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2019.5 сард



2.2 Төсөв, санхүү

2019 оны 05 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 28953.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 94.8 хувь байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 32.4 хувийг татварын, 15.0 хувийг татварын бус орлого, 52.6 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2019 оны 05-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 532.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг төлөвлөгөөнөөс 89.5 (20.2%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 05 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.5 хувь, өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар тус тус өсчээ.


Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.5 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 4.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.1 хувь, хувцас бөс бараа, гутал 0.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.2 хувь, тээврийн бүлэг 1.0 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 0.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 9.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 2.9 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 2.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.6 хувь гэр ахуйн тавилгын бүлэг 2.7 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 5.5 хувь, тээврийн бүлэг 5.0 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 4.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 6.0 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 5.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 03 дүгээр сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018-2019 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015-2019 оны 05 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 929.6 мянган хээлтэгч малын 652.4(70.2%) мянга нь 2019 оны эхний 5 сард төллөсөн байна. Эм хонины 80.1 хувь, эм ямааны 69.7 хувь, ингэний 37.0 хувь, үнээний 28.9 хувь, гүүний 24.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.7 хувь буюу 644.6 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 104.6 (19.4%) мянгаар нэмэгдсэн байна. Дэлгэрэх суманд 74.8 мянга, Даланжаргалан суманд 71.6 мянга, Айраг суманд 57.9 мянга, Иххэт суманд 55.7 мянга, Алтанширээ суманд 52.3 мянга, Өргөн суманд 49.4 мянга, Сайхандулаан суманд 46.8 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 62.6 хувийг эзэлж байна.



Том малын зүй бус хорогдол 2019 оны эхний 5 сард аймгийн хэмжээнд 3858 болж, өмнөх оны мөн үеэс 3082 (44.4%) толгойгоор буурав. Нийт хорогдсон малын 37.2 хувийг хонь, 56.7 хувийг ямаа эзэлж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 05-р сард ноолуурын дундаж үнэ 72000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 23000 (24.2%) төгрөгөөр буурсан байна. Харин үхрийн шир 3.0 мянган төгрөгийн ханштай байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах, Хөвсгөл сумдад хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1200.0 мянган төгрөг Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан шар Алтанширээ, Эрдэнэ сумдад хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Иххэт, Мандах, Сайхандулаан, Хөвсгөл, Сайншанд, Замын-Үүд сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Эрдэнэ суманд хамгийн их буюу 250.0 мянган төгрөг, Хатанбулаг суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Эрдэнэ суманд хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 05 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 71966.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 126852.3 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 9.5 хувиар, борлуулалт 75.8 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5.6 хувийг төрийн, 94.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 5.6 хувь, компани 94.0 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 27.0 мян.ккалаар, ус түгээлт 112.5 мян.м3-аар, сувагжуулалт 134.0 мян.м3-аар, савласан цэвэр ус 71.5 мян.литрээр, талх 19.7 тонноор, нарийн боов 18.3 тонноор, хиам 6.3 тонноор, сүүн бүтээгдэхүүн 10.1 мян.литрээр, банш бууз 1.7 тонноор, бетон зуурмаг 628 мян.м3-аар, шохой 10 тонноор, цемент 14.2 мян.тонноор, модон эдлэл 1188 мян.төгрөгөөр, дээл 26 ширхгээр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

2019 оны 5 дугаар сард сарын дундаж агаарын температур Замын-Үүд, Хөвсгөл, Хатанбулаг сумдад 15.3-16.3 градус дулаан, Дэлгэрэх суманд 13.3 градус дулаан, бусад



сумдын нутгаар 14.0-14.7 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 32-36 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД /-тай харьцуулахад: Иххэт, Эрдэнэ сумдад ОЖД-аас дулаан, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 2-7 градус хүйтэн, өдөртөө нийт сумдын нутгаар 52-56 градус дулаан байв.

5 дугаар сард Замын-Үүд суманд хамгийн их буюу 10 өдөр хур тунадастай, бусад сумдын нутгаар 1...5 өдөр хур тунадастай байж, 2.3...22.9 мм хур тунадас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Айраг, Дэлгэрэх, Иххэт, Хатанбулаг сумдад ОЖД-аас бага, бусад сумдын нутгаар ОЖД-аас ахиу тунадас орсон байна.

Энэ сард салхины хамгийн их хурд Өргөн суманд секундэд 14 метр, бусад сумдын нутгаар секундэд 20-29 метр хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. 10 м/с-ээс дээш салхитай 9...27 өдөр байлаа.

5 дугаар сарын 25-ны байдлаар ихэнх сумдын нутгаар таана, хялганы цухуйлт жигдэрсэн, хазаар зарим сумдын нутгаар цухуйлтгүй, ургамлын дундаж өндөр 2-4 см, сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр бэлчээрийн ургамлын ургалтын байдал Эрдэнэ сум, Мандах сумын хойд болон зүүн, Өргөн сумын зүүнээс бусад хэсгээр хэвийн, Айраг, Дэлгэрэх, Иххэт сумд, Алтанширээ сумын баруунаас бусад, Хатанбулаг сумын зүүн болон өмнө хэсгээр ургамлын ургалт жигдрээгүй өсөлт нь удаашралтай, муу, бусад сумдын нутгаар ургамлын ургалт дунд зэрэг байна.

МАА-н үйлдвэрлэлд: Нийт нутгаар төл хүлээн авах, зарим сумдын нутгаар отор нүүдэл хийх ажил явагдаж байна. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.

_____ о О о _____



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2019 ОНЫ 5 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	63.1	68.2	69.6	69.7	100.1
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	612	523	565	522	92.4
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	144	147	160	167	104.4
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	468	376	405	355	87.7
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	2	3	1	3	3.0 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	3.3	5.7	1.8	5.7	3.2 ²
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 058	1 650	860	885	102.9
- Үүнээс эмэгтэй	тоо	557	704	408	443	108.6
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	25	38	20	204	1021.2
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	145	121	92	3	3.3
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	122	121	65	2	3.1
Улирлын чанартай ажлын байр	тоо	23	0	27	1	0.0
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	1294	447	306	407	133.0
- 10000 хүнд ногдох	тоо	194	66	44	58	132.6
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	272	276	251	242	96.4
- 10000 хүнд ногдох ***	тоо	64	64	58	54	93.8
6.Бойжиж буй төл	толгой	441386	518330	540011	644608	119.4
- Унага	толгой	8544	11900	12312	11046	89.7
- Тугал	толгой	8909	9640	11291	9182	81.3
- Ботго	толгой	5268	5714	5834	6272	107.5
- Хурга	толгой	225379	264407	274539	331397	120.7
- Ишиг	толгой	193286	226669	236035	286711	121.5
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	7462.9	35308.0	79542.4	71966.6	90.5
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	4890.1	69985.6	112477.0	126852.3	112.8

* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

** -Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2018 I-V	2019 I-V	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	154.0	171.5	17.5	111.4
2. Ор хоног	мян.хүн	54.6	53.0	-1.6	97.1
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	4.6	4.6	0	100.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	7.6	7.4	-0.2	97.4
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	8.7	8.8	0.1	101.1
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.5	1.3	-0.2	86.7
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1299	1165	-134	89.7
Үүнээс: нас баралт	хүн	32	33	1	103.1
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	665	775	110	116.5
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	575	690	115	120.0
8. Амаржсан эх	хүн	563	520	-43	92.4
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	2	1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	8	3	-5	

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 05 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	520	0	522	2	2
Айраг					1
Алтанширээ					
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан	1				
Улаанбадрах					
Хатанбулаг					
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ	1		1		
Сайншанд	407		410	2	1
Замын - Үүд	109		109		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	306	407	101	133.0
Вируст гепатит	2	3	1	150.0
Сүрьеэ	40	35	-5	87.5
Тэмбүү	43	65	22	151.2
Заг хүйтэн	89	96	7	107.9
Трихоминиаз	36	68	32	188.9
Цусан суулга	13	17	4	130.8
Бусад	83	123	40	148.2

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 05 сард

Боловсролын түвшингээр	2016 V	2017 V	2018 V	2019 V	2019 V 2016 V	2019 V 2018 V
	хүний тоо				хувь	
ДҮН	1 058	1 650	860	885	83.6	102.9
Үүнээс: Эмэгтэй	557	804	408	443	79.5	108.6
Магистр, доктор	7	7	1	2	28.6	200.0
Дээд боловсролтой	253	385	168	114	45.1	67.9
Тусгай дунд	129	148	43	36	27.9	83.7
Техник мэргэжлийн	126	138	55	37	29.4	67.3
Бүрэн дунд	366	763	515	596	162.8	115.7
Бүрэн бус дунд	142	157	52	67	47.2	128.8
Бага	29	29	6	13	44.8	216.7
Боловсролгүй	6	23	20	20	333.3	100.0

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 05 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2018 V	2019 V	2018 I-V	2019 I-V	2018 I-V	2019 I-V
ДҮН	860	885	133	220	1074	3
Айраг	20	42	14	2	62	1
Алтанширээ	29	25	7	17	56	0
Даланжаргалан	38	40	6	20	40	0
Дэлгэрэх	22	12	3	5	12	0
Иххэт	39	16	18	1	54	0
Мандах	23	9	16	0	43	0
Өргөн	25	12	13	68	37	2
Сайхандулаан	13	15	1	2	17	0
Улаанбадрах	21	10	16	11	47	0
Хатанбулаг	19	12	0	7	32	0
Хөвсгөл	7	9	7	5	17	0
Эрдэнэ	21	44	2	8	30	0
Сайншанд	445	460	21	34	454	0
Замын - Үүд	138	179	9	40	173	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2019 оны 05 сарын эцэст

Салбарын ангилал	2018 I-V	2019 I-V
	Тоо	
Бүгд	204	231
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	2	19
Уул уурхай олборлох аж үйлдвэр	109	99
Боловсруулах үйлдвэрлэл		
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын Барилга	5	6
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	8	1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		2
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6	4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа,	19	21
Боловсрол	10	13
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	14	4
Урлаг, үзвэр,тоглоом наадам	7	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	19	60
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл		

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2019 оны 05 сарын эцэст

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V
	Тоо	
Бүгд	204	231
Менежер	1	5
Мэргэжилтэн	53	32
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	26	37
Контор, үйлчилгээний ажилтан	11	9
Худалдаа, үйлчилгээний ажилтан	13	11
ХАА, ой загас агнуурын ажилтан	2	15
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	17	10
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	28	18
Энгийн ажил мэргэжил	44	93
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	9	1

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2018 I-V		2019 I-V	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	133	60	220	92
Менежер	2	2	3	3
Мэргэжилтэн	22	16	31	24
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	13	10	36	13
Контор, үйлчилгээний ажилтан	9	6	9	9
Худалдаа, үйлчилгээний ажилтан	13	8	9	7
ХАА, ой загас агнуурын ажилтан			15	5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	10	3	10	3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	16	5	17	1
Энгийн ажил мэргэжил	39	6	89	26
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	9	4	1	1

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2019 оны 05 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	3	2	2	1
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур				
Уул уурхай олборлолт	1			1
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ				
Тээвэр агуулахын үйл ажиллагаа				
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа				
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	1	1	1	
Боловсрол				
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2019 I-V 2018 I-V
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	13 009.5	17 085.8	131.3
Тэтгэврийн даатгалын сан	8 175.9	10 783.3	131.9
Тэтгэмжийн даатгалын сан	925.5	1 222.0	132.0
Эрүүл мэндийн даатгалын сан	2 186.4	2 809.5	128.5
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1 349.5	1 780.7	132.0
Ажилгүйдлийн даатгалын сан	372.2	490.3	131.7
Нийгмийн даатгалын сангийн зарлага	17 953.0	20 999.4	117.0
Тэтгэврийн даатгалын сан	13 162.5	15 246.5	115.8
Тэтгэмжийн даатгалын сан	1 041.4	1 210.9	116.3
Эрүүл мэндийн даатгалын сан	2 699.7	2 879.5	106.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	729.6	1 248.2	171.1
Ажилгүйдлийн даатгалын сан	319.8	414.3	129.5

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2019 I-V 2018 I-V
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	17321	17305	99.9
Албан журмаар даатгуулагчид	15175	15737	103.7
Аж ахуй нэгж, байгууллага	7633	8186	107.2
Төсөвт байгууллага	7542	7551	100.1
Сайн дураар даатгуулагчид	2146	1568	73.1
2. Тэтгэвэр авагчдын тоо	8120	8509	104.8
Өндөр насны тэтгэвэр	5816	6136	105.5
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1209	1281	106.0
Тэжээгчээ алдсаны	520	504	96.9
Цэргийн тэтгэвэр	418	438	104.8
ҮОМШӨ*-ний	157	150	95.5
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	13 513.0	15 599.8	115.4
Өндөр насны тэтгэвэр	9 871.6	11 341.4	114.9
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1 516.3	1 784.9	117.7
Тэжээгчээ алдсаны	666.3	741.0	111.2
Цэргийн тэтгэвэр	1 095.5	1 374.3	125.4
ҮОМШӨ*-ний	363.3	358.2	98.6

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2018 I-V	2019 I-V	2019 I-V 2018 I-V
	сая төгрөг		хувь
ДҮН	13009.5	17085.8	131.3
Айраг	228.9	313.0	136.7
Алтанширээ	83.0	99.4	119.8
Даланжаргалан	598.1	791.4	132.3
Дэлгэрэх	96.6	133.4	138.1
Иххэт	134.8	211.5	156.9
Мандах	169.5	132.3	78.1
Өргөн	253.6	595.7	2.3 ²
Сайхандулаан	110.4	155.4	140.8
Улаанбадрах	109.9	134.9	122.7
Хатанбулаг	240.5	312.6	130.0
Хөвсгөл	115.2	130.7	113.5
Эрдэнэ	185.8	242.3	130.4
Сайншанд	7309.8	9417.4	128.8
Зүүнбаян баг	384.1	488.2	127.1
Замын-Үүд	2989.3	3927.6	131.4

Тайлбар: ²- дахин их

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2018 I-V	2019 I-V	2019 I-V 2018 I-V
	сая төгрөг		хувь
ДҮН	17953.0	20999.4	117.0
Айраг	937.5	1032.2	110.1
Алтанширээ	360.0	385.1	107.0
Даланжаргалан	747.8	938.5	125.5
Дэлгэрэх	363.9	426.0	117.1
Иххэт	672.7	752.3	111.8
Мандах	394.1	428.3	108.7
Өргөн	562.4	870.4	154.8
Сайхандулаан	263.6	302.4	114.7
Улаанбадрах	399.9	455.5	113.9
Хатанбулаг	675.1	827.3	122.5
Хөвсгөл	341.9	372.2	108.9
Эрдэнэ	604.5	693.8	114.8
Сайншанд	7546.4	8927.8	118.3
Зүүнбаян баг	670.8	758.5	113.1
Замын-Үүд	3412.4	3829.1	112.2



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-V 2018 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-V 2018 I-V
	2018 I-V	2019 I-V		2018 I-V	2019 I-V	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	19940	20612	103.4	3339.2	3459.1	103.6
1. Халамжийн тэтгэвэр	1306	1436	110.0	934.5	1045.0	111.8
Ахмад настны тэтгэвэр	56	81	144.6	39.8	56.1	141.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1250	1355	108.4	894.7	988.9	110.5
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1020	1035	101.5	316.5	322.6	101.9
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	960	982	102.3	296.7	302.5	102.0
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	48	45	93.8	16.4	16.9	103.0
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	6	100.0	1.7	2.5	147.1
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	5	2	40.0	1.1	0.7	63.6
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1			0.6	0.0	
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	893	825	92.4	226.7	264.4	116.6
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	226	315	139.4	159.0	172.1	108.2
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	646	371	57.4	42.9	35.9	83.7
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	4	130	30.7 ²	0.4	40.8	107.1 ²
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	5	6	120.0	10.0	12.0	120.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-V 2018 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-V 2018 I-V
	2018 I-V	2019 I-V		2018 I-V	2019 I-V	
	тоо		хувь	сая төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	4	1	25.0	4.8	1.2	25.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	5	1	20.0	6.0	1.2	20.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	3	1	33.3	3.6	1.2	33.3
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0		0	0	
5. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	6135	6873	112.0	296.5	262.9	88.7
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3381	3434	101.6	76.9	83.1	108.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	154	341	221.4	21.8	30.6	140.4
